



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/61

Мандалговь

“Мандал өргөө голомт” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйл 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Биеийн тамир, спортын газрын барилгын дээврийн засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Мандал өргөө голомт” ХХК-тай 135,418,820 (нэг зуун гучин таван сая дөрвөн зуун арван найман мянга найман зуун хорь) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу барилгын дээврийн засварын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мандал Өргөө Голомт” ХХК-ний захирал (М.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л.ДОРЖБАТ



4822150133